



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Завхан аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй, 22 нэрийн, нийт 30,444,833.04 (гучин сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун гучин гурван төгрөг дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Завхан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Балжинням нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж данснаас хасах хөрөнгөөс сэлбэг, хоёрдогч түүхий эд, төмрийн хаягдлыг ялган тоолж бүртгэх, худалдах, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



132001548

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн
333 дугаар тогтоолын хавсралт

ЗАВХАН АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад (дахин үнэлсэн) орсон огноо	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
						(төгрөг)	
Машин, тоног төхөөрөмж							
1	Зөөврийн компьютер	ш	1	2012-02-29	950,000.00	950,000.00	0
2	Тог баригч	ш	5	2017-12-31	125,290.00	626,450.00	0
3	Анжис	ш	1	2014-12-31	2,800,000.00	2,800,000.00	0
4	Төмс үрлэгч	ш	1	2014-12-31	7,500,000.00	7,500,000.00	0
5	Зөөврийн компьютер	ш	1	2009-10-25	1,200,000.00	1,200,000.00	0
6	Компьютер	ш	1	2011-03-31	690,000.00	690,000.00	0
7	Компьютер ЦСҮТ	ш	1	2012-06-01	1,210,000.00	1,210,000.00	0
8	Сийрүүлэгч	ш	1	2014-12-31	4,900,000.00	4,900,000.00	0
9	Сийрүүлэгч к	ш	1	2014-12-31	4,900,000.00	4,900,000.00	0
10	Компьютер dell	ш	1	2017-12-31	1,208,350.00	1,208,350.00	0
11	Принтер	ш	1	2017-12-31	264,880.00	264,880.00	0
12	Проектор	ш	1	2010-03-31	1,495,000.00	1,495,000.00	0
13	Зөөврийн компьютер	ш	1	2017-12-31	1,201,310.00	1,201,310.00	0
	Машин, тоног төхөөрөмжийн дүн		17			28,945,990.00	0
Тавилга, аж ахуйн эд хогшил							
14	BC-M2 түмбочка	ш	1	1990-01-01	191,030.40	191,030.40	0
15	Теннис ширээ	ш	1	1999-07-01	5,793.87	5,793.87	0
16	GE -120 ширээ	ш	2	2002-10-23	119,393.79	238,787.57	0
17	GFH3 түмбочик	ш	2	2002-11-20	95,514.70	191,029.39	0
18	808 Шүүгээ	ш	1	2002-07-23	151,231.46	151,231.46	0

19	GE -841 шкаф	ш	1	2002-10-23	246,746.15	246,746.15	0
20	Сандап 9933	ш	2	2002-10-23	48,662.10	97,324.20	0
21	Бичгийн ширээ с	ш	1	2008-06-13	110,900.00	110,900.00	0
22	Сандап	ш	14	2008-12-30	19,000.00	266,000.00	0
	Тавилга, аж ахуйн эд хогшлын дүн		25			1,498,843.04	0
	Нийт дүн		42			30,444,833.04 (гучин сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга найман зуун гучин гурван төгрөг дөрвөн мөнгө)	0